



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,814,899,834.93 (нэг тэрбум найман зуун арван дөрвөн сая найман зуун ерэн есөн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 541,402,232.28 (таван зуун дөчин нэгэн сая дөрвөн зуун хоёр мянга хоёр зуун гучин хоёр төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Бадарч нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг сургуулийн эзэмшилд хэвээр үлдээж, цаашид зориулалтын дагуу нөхөн сэргээж ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 05 дугаар сарын 02 ны өдрийн
 167 дугаар тогтоолын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хичээлийн 3-р байр	1956.01.01	1,617,605,889.00	500,690,815.56	1,116,915,073.44
2	Хичээлийн 3-р байрны өргөтгөл	1999.01.01	197,293,945.93	40,711,416.72	156,582,529.21
	Нийт дүн	-	1,814,899,834.93 (нэг тэрбум найман зуун арван дөрвөн сая найман зуун ерэн есөн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг ерэн гурван мөнгө)	541,402,232.28 (таван зуун дөчин нэгэн сая дөрвөн зуун хоёр мянга хоёр зуун гучин хоёр төгрөг хорин найман мөнгө)	1,273,497,602.65 (нэг тэрбум хоёр зуун далан гурван сая дөрвөн зуун ерэн долоон мянга зургаан зуун хоёр төгрөг жаран таван мөнгө)